СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

Сүхбаатар аймгийн Онгон сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** СБА-2023/42/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баруун-Урт сум<br>2023 он | Дарга,<br>тэргүүлэх аудитор: М.Нарантуяа<br>Утас: 70518396<br>Аудитын менежер: Г.Даваа<br>Утас: 70512123<br>Аудитор: О.Барчидгүнсэн<br>Утас: 70512127 |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ..... 3
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ..... 5
**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ..... 11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ..... 11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ..... 11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ..... 12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 13
**4. АУДИТЫН ТАЙЛАН** ..... 14
4.1 Ерөнхий зүйл ..... 14
4.2 Материаллаг байдал ..... 14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ..... 15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 15
4.5.1 Завсрын аудитын талаар ..... 15
**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ..... 16
5.1 Албан шаардлага ..... 16
5.2 Зөвлөмж ..... 16
**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ..... 17

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2023.02.24 № 55

танай ____________-ны №____________-т

СҮХБААТАР АЙМГИЙН ОНГОН СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Б.БАТБИЛЭГ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Онгон сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Сүхбаатар аймгийн Онгон сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

**Аудитын гол асуудал**

Сүхбаатар аймгийн Онгон сумын Засаг даргын Тамгын газар нь төрийн албан хаагчдын цалингийн нэгдсэн системд бүрэн нэвтэрч, төрийн сангийн ажил гүйлгээг цахим болох бэлтгэл ажлын хангаж ажиллаж байна.

**Бусад асуудлын хэсэг**

Сүхбаатар аймгийн Онгон сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 28 арга хэмжээг төлөвлөн, гүйцэтгэл 89.3 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.НАРАНТУЯА

D:/Bichig hereg/2023/A4 toot

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **59,048,737.43** | **139,209,490.00** |
| **33** | **АВЛАГА** | 22,000,000.00 | 22,000,000.00 |
| **335** | **Бусад авлага** | 22,000,000.00 | 22,000,000.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 22,000,000.00 | 22,000,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 37,048,737.43 | 112,209,490.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 15,318,737.43 | 9,262,090.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,425,650.00 | 2,733,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 11,898,087.43 | 3,640,490.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | - | 555,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | - | 788,100.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 995,000.00 | 1,545,000.00 |
| 35600 | Мал амьтад | 21,730,000.00 | 102,947,400.00 |
| **36** | **НӨӨЦИЙН БАРАА** | - | 5,000,000.00 |
| 36300 | Тэжээлийн нөөц | - | 5,000,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,068,089,170.61** | **1,128,575,186.06** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,068,089,170.61 | 1,128,575,186.06 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,059,465,170.53 | 1,117,581,217.19 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 481,937,515.00 | 500,937,515.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (85,440,268.49) | (110,886,144.49) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 181,293,941.00 | 248,793,941.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (110,055,736.80) | (121,265,022.72) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 123,945,768.30 | 120,034,998.30 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (56,568,524.21) | (58,930,284.49) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 55,089,346.60 | 53,101,846.60 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (47,402,969.76) | (47,191,543.97) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 732,445,360.00 | 780,477,874.48 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (215,779,261.11) | (247,491,962.52) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 8,624,000.08 | 10,993,968.87 |
| 39301 | Програм хангамж | 2,109,000.00 | 4,104,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,628,999.92) | (1,976,031.13) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 8,144,000.00 | 8,866,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,127,137,908.04** | **1,267,784,676.06** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **890,000.00** | **-** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 890,000.00 | - |
| **413** | **Өглөг** | 890,000.00 | - |
| **4136** | **Бусад өглөг** | 890,000.00 | - |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 890,000.00 | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,126,247,908.04** | **1,267,784,676.06** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,126,247,908.04 | 1,267,784,676.06 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 582,814,585.17 | 582,814,585.17 |
| 51101 | Өмч: - төрийн | 582,814,585.17 | 582,814,585.17 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 295,327,304.57 | 436,864,072.59 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 295,327,304.57 | 295,327,304.57 |

| | | | |
|---|---|---|---|
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 141,536,768.02 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 248,106,018.30 | 248,106,018.30 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,127,137,908.04** | **1,267,784,676.06** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **592,165,877.48** | **915,879,216.48** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **50,000.00** | **225,551,914.48** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 50,000.00 | 225,551,914.48 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 50,000.00 | 57,297,400.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 50,000.00 | 1,650,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | - | 55,647,400.00 |
| 1200017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан -Үндсэн хөрөнгө | | 135,254,514.48 |
| 1200018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан - Бараа материал | | 33,000,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **592,115,877.48** | **690,327,302.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 106,560,938.00 | 21,700,852.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 18,699,600.00 | - |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 75,357,729.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 7,741,109.00 | 1,329,200.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 4,762,500.00 | 20,371,652.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 471,341,900.00 | 668,626,450.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 471,341,900.00 | 668,626,450.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 14,213,039.48 | - |
| 133002 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 14,213,039.48 | - |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **578,102,923.09** | **774,101,281.89** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **578,102,923.09** | **774,101,281.89** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 571,109,523.09 | 690,620,727.60 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 247,215,333.74 | 266,899,321.87 |
| 210101 | Үндсэн цалин | 203,764,569.86 | 208,042,344.05 |
| 210102 | Нэмэгдэл | 38,968,030.88 | 44,766,387.21 |
| 210104 | Урамшуулал | 335,233.00 | 11,421,723.61 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 4,147,500.00 | 2,668,867.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 35,519,959.24 | 34,761,604.78 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24,491,359.24 | 23,938,947.11 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,757,200.00 | 2,816,276.51 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,205,700.00 | 2,249,577.22 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 551,400.00 | 504,450.25 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,514,300.00 | 5,252,353.69 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 33,201,191.24 | 32,863,387.39 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,939,064.24 | 3,532,362.39 |
| 210302 | Түлш, халаалт | 28,181,727.00 | 29,251,025.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 80,400.00 | 80,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 28,703,608.00 | 75,207,305.43 |

| | | | |
|---|---|---|---|
| 210401 | Бичиг хэрэг | 2,769,554.00 | 4,234,268.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 21,838,374.00 | 55,005,650.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,628,180.00 | 2,467,890.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 138,600.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 3,095,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 328,900.00 | 10,404,497.43 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,466,200.00 | 3,957,300.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 957,500.00 | 1,294,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,508,700.00 | 2,663,300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,836,000.00 | 6,561,600.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,836,000.00 | 6,561,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 114,346,637.00 | 54,257,695.67 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 112,994,794.00 | 53,650,666.67 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 64,350.00 | 70,700.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 281,881.00 | 220,275.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 66,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 779,492.00 | 240,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 164,120.00 | 10,054.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 40,000.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 101,820,593.87 | 216,112,512.46 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 40,319,410.00 | 131,750,180.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 900,250.00 | 340,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 60,600,933.87 | 84,022,332.46 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 6,993,400.00 | 83,480,554.29 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | - | 80,000.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | - | 80,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 6,993,400.00 | 47,401,872.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 6,193,400.00 | 6,113,400.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | - | 15,660,072.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 25,068,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 800,000.00 | 560,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 35,998,682.29 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 35,998,682.29 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **14,062,954.39** | **141,777,934.59** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **14,062,954.39** | **141,777,934.59** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **577,952,838.00** | **691,977,302.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **50,000.00** | **1,650,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 50,000.00 | 1,650,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 50,000.00 | 1,650,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 50,000.00 | 1,650,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **577,902,838.00** | **690,327,302.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 106,560,938.00 | 21,700,852.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 18,699,600.00 | - |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 75,357,729.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 7,741,109.00 | 1,329,200.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 4,762,500.00 | 20,371,652.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 471,341,900.00 | 668,626,450.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 471,341,900.00 | 668,626,450.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **531,983,278.70** | **682,482,302.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **531,983,278.70** | **682,482,302.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **510,776,839.22** | **599,001,747.71** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 246,325,333.74 | 267,774,321.87 |
| 210101 | Үндсэн цалин | 202,874,569.86 | 208,917,344.05 |
| 210102 | Нэмэгдэл | 38,968,030.88 | 44,766,387.21 |
| 210104 | Урамшуулал | 335,233.00 | 11,421,723.61 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 4,147,500.00 | 2,668,867.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 35,519,959.24 | 34,761,604.78 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24,491,359.24 | 23,938,947.11 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,757,200.00 | 2,816,276.51 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,205,700.00 | 2,249,577.22 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 551,400.00 | 504,450.25 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,514,300.00 | 5,252,353.69 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 33,201,191.24 | 32,863,387.39 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,939,064.24 | 3,532,362.39 |
| 210302 | Түлш, халаалт | 28,181,727.00 | 29,251,025.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 80,400.00 | 80,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 29,529,408.00 | 34,503,658.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,424,254.00 | 4,234,618.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 21,838,374.00 | 23,707,100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,628,180.00 | 2,567,890.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 138,600.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 3,174,450.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 500,000.00 | 819,600.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 301,000.00 | 49,450.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 301,000.00 | 49,450.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 11,738,150.00 | 5,338,300.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,512,500.00 | 2,088,300.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 250,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 10,225,650.00 | 3,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,836,000.00 | 6,561,600.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,836,000.00 | 6,561,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 107,283,047.00 | 55,906,195.67 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 105,900,204.00 | 55,131,666.67 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 64,350.00 | 70,700.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 281,881.00 | 220,275.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 66,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 810,492.00 | 407,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 164,120.00 | 10,054.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 40,000.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 42,042,750.00 | 161,243,230.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 41,142,500.00 | 160,643,230.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 900,250.00 | 600,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **21,206,439.48** | **83,480,554.29** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 6,993,400.00 | 47,481,872.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 6,193,400.00 | 6,193,400.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | - | 15,660,072.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 25,068,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 800,000.00 | 560,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 14,213,039.48 | 35,998,682.29 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 14,213,039.48 | 35,998,682.29 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **45,969,559.30** | **9,495,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **45,969,559.30** | **9,495,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **45,969,559.30** | **9,495,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 45,969,559.30 | 9,495,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 45,969,559.30 | 9,495,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(45,969,559.30)** | **(9,495,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (0.00) | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 582,814,585.17 | 248,106,018.30 | 5,275,992.51 | | 836,196,595.98 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **582,814,585.17** | **248,106,018.30** | **5,275,992.51** | - | 836,196,595.98 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 248,707,210.43 | | 248,707,210.43 |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **582,814,585.17** | **248,106,018.30** | **253,983,202.94** | - | 1,084,903,806.41 |
| D01 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **582,814,585.17** | **248,106,018.30** | **253,983,202.94** | - | 1,084,903,806.41 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **582,814,585.17** | **248,106,018.30** | **253,983,202.94** | - | 1,084,903,806.41 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 141,536,768.02 | | 141,536,768.02 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **582,814,585.17** | **248,106,018.30** | **395,519,970.96** | - | 1,226,440,574.43 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 669846300.00 | 635319419.71 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 669846300.00 | 635319419.71 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 620197200.00 | 587837547.71 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 284211000.00 | 267774321.87 |
| 210101 | Үндсэн цалин | 187641400.00 | 208917344.05 |
| 210102 | Нэмэгдэл | 60784000.00 | 44766387.21 |
| 210104 | Урамшуулал | 12620500.00 | 11421723.61 |

| | | | |
|---|---|---|---|
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 23165100.00 | 2668867.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 35526500.00 | 34761604.78 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24157900.00 | 23938947.11 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2842100.00 | 2816276.51 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2273700.00 | 2249577.22 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 568500.00 | 504450.25 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5684300.00 | 5252353.69 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 34248100.00 | 32863387.39 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6347000.00 | 3532362.39 |
| 210302 | Түлш, халаалт | 27301100.00 | 29251025.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 600000.00 | 80000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 29475000.00 | 28939458.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3000000.00 | 4234618.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 18600000.00 | 18577900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,200,000.00 | 2,517,890.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,175,000.00 | 3,174,450.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 500,000.00 | 434,600.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 125,000.00 | 49,450.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 125,000.00 | 49,450.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 12,850,000.00 | 5,338,300.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 9,600,000.00 | 2,088,300.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 250,000.00 | 250,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,000,000.00 | 3,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 7,000,000.00 | 6,561,600.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,000,000.00 | 6,561,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 94,761,600.00 | 50,306,195.67 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 90,841,600.00 | 49,531,666.67 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 225,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 765,000.00 | 70,700.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 284,000.00 | 220,275.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 95,000.00 | 66,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,391,000.00 | 407,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 110,000.00 | 10,054.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 50,000.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 122,000,000.00 | 161,243,230.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 121,000,000.00 | 160,643,230.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,000,000.00 | 600,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 49,649,100.00 | 47,481,872.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 49,649,100.00 | 47,481,872.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 6,193,400.00 | 6,193,400.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 43,455,700.00 | 15,660,072.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 25,068,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 560,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 669,846,300.00 | 668,626,450.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 669,846,300.00 | 668,626,450.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 669,846,300.00 | 668,626,450.00 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 22.00 | 22.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 8.00 | 8.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 11.00 | 11.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 3.00 | 3.00 |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **11,164,200.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **11,164,200.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 11,164,200.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 5,564,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,129,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 50,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 385,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5,600,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,600,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 21,700,852.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 21,700,852.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,329,200.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 20,371,652.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Онгон сумын Засаг даргын Тамгын газар нь "Төрийн албаны нэгдмэл байдлыг хангаж, төрийн мэргэшсэн албан хаагчдаар төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай үзүүлж, төрийн бодлого шийдвэрийг цаг алдалгүй хүргэнэ гэсэн зорилго зорилтын дор ажиллаж байна" эрхэм зорилгын хүрээнд сумын нийгэм эдийн засгийн чадавхыг дээшлүүлэхэд чиглэсэн оновчтой бодлого, нийгмийн салбарын хөгжлийг ахиулахад дэмжлэг үзүүлэх зорилго, үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзсэн.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Онгон сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Онгон сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 140,646.7 мянган төгрөгөөр буюу 12.4 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| ***Үзүүлэлт*** | ***Эхний үлдэгдэл*** | ***Эцсийн үлдэгдэл*** | ***Өөрчлөлт*** |
|---|---|---|---|
| ***Б*** | 1 | 2 | 3=2-1 |
| ***Мөнгөн хөрөнгө*** | - | - | |
| ***Авлага*** | 22,000.0 | 22,000.0 | - |
| ***Бараа материал*** | 37,048.7 | 112,209.5 | 75,160.8 |
| ***Үндсэн хөрөнгө*** | 1,068,089.1 | 1,128,575.1 | 60,486.0 |
| ***Нийт хөрөнгө*** | **1127137.9** | **1267784.6** | **140,646.7** |
| ***Өр төлбөр*** | 890.0 | | -890.0 |
| ***Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/*** | *1126247.9* | *1267784.6* | 141,536.7 |
| ***Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн*** | **1,127,137.9** | **1,267,784.6** | **140,646.7** |

- *Бараа материал дансны эцсийн үлдэгдэл 75,160.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь аймгийн ОНХС-аас Сэлэнгэ үүлдрийн бух 8 толгой, үзэмчин үүлдрийн хуц 60 толгой мал нэмэгдсэн нөлөөлсөн байна.*

- *Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 1,128,575.1 мянган төгрөг болж 60,486.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, үнэ төлбөргүй 114,176.3 мянга, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 9,495.0 мянга, нийт 146,035.5 мянган төгрөгөөр нэмэгдэж, 13,398.2 мянган төгрөг хөрөнгийг акталж, хөрөнгийн элэгдлээр буурсан нөлөөлсөн байна.*
- *Засгийн газрын хувь оролцоо данс 141,536.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүн нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.*

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 461,818.9 мянган төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс орон төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 423,419.8 мянга төгрөг батлагдсан байна.

**3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг орон нутгийн санхүүжилт 669,846.3 мянган төгрөгөөр төсөв батлагдсанаас 635,319.4 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн санхүүжилт 668,626.4 мянга, төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн санхүүжилтээс 35,998.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 668,626.4 мянган төгрөг буюу 89.3 хувьтай зарцуулсан байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 80101-Үндсэн үйл ажиллагаа | 346,962.40 | 331663.5 | 15,298.90 | 95.6 |
| 2 | 80106-Баг, хорооны үйл ажиллагааны зардал | 60,393.20 | 54484.2 | 5,909.00 | 90.2 |
| 3 | 80714-Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт | 6,193.40 | 6193.4 | 0.00 | 100.0 |
| 4 | 80802-ажил олгогчоос олгох тэтгэмж | 43,455.70 | 41288.5 | 2,167.20 | 95.0 |
| 5 | 81102-Орон нутгийн нөөц хөрөнгө | 30,000.00 | 30,000.00 | 0.00 | 100.0 |
| 6 | 81518-Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зардал | 77,500.00 | 77364.8 | 135.20 | 99.8 |
| 7 | 81549-Ахмадын сан | 1,500.00 | 1499.4 | 0.60 | 100.0 |
| 8 | 81701-Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх | 88,841.60 | 87323.9 | 1,517.70 | 98.3 |
| 7 | 82310-Гамшгаас сэргийлэх сургалт суртчилага | 12,000.00 | 11,996.60 | 3.40 | 100.0 |
| 8 | 82212-Хур хог хаягдал орчны бохирдлыг устгах цэвэрлэх үйлчилгээ | 3,000.00 | 3,000.00 | 0.00 | 100.0 |
| НИЙТ | | 669846.3 | 644814.4 | 25032.0 | 96.3 |

Тус газар нь орон тоо дутуу ажилласан нөлөөлсөн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 1,329.2 мянга, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого 22,021.6 мянга нийт 23350.6 мянган төгрөгийн орлого төвлөрч гүйцэтгэлээр 11,164.2 мянган төгрөгийг зарцуулж 12186.6 мянган төгрөгийг дээд шатны төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулалтыг авч үзвэл тээвэр шатахууны зардалд 5,129.2 мянга, бусад зардалд 6,035.0 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### *3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Онгон сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Барчидгүнсэн, гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Онгон сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 578,102.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,671.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1[1], 15,2.3[2]-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад байр ашиглалттай холбоотой тогтмол зардлууд 337.9 мянган төгрөгөөр буурсан, бичиг хэрэг, тээвэр шатахууны зардал 34,632.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Дээрх зардал өмнөх оноос нэмэгдсэн учир шалтгааныг авч үзвэл:

- *Тээвэр шатахуун, бичиг хэргийн зардал: Шатах тослох материал, бичиг хэргийн материалын үнэ өмнөх оноос дунжаар 52.0 хувиар нэмэгдсэн нь гол нөлөөлөл үзүүлсэн байна.*

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тайлант онд гарсан өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гаргасан тушаал шийдвэр, орлого зарлагын мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулсан байна.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Сүхбаатар аймгийн Онгон сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

*Хүснэгт 3 Албан* шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

[1] байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

[2] сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Хувь** |
| Төлбөрийн акт | 2 | 910.2 | 2 | 910.2 | 100 |
| Албан шаардлага | 4 | 17,580.0 | 4 | 17,580.0 | 100 |
| Зөвлөмж | 1 | - | 1 | - | 100 |
| Нийт дүн | **7** | - | **7** | - | **100** |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 2 алдаа 1 зөрчил илэрснээс алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 1 албан шаардлага, 2 зөвлөмж өглөө.

### 5.1 Албан шаардлага

5.1.1 Шилэн дансны цахим системд тайлант онд гарсан өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан тушаал шийдвэрийг байршуулаагүй. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8[3] заасныг зөрчсөнд албан шаардлага өгөв.

### 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***5.2. Зардалтай холбоотой асуудал***

*5.2.1 Илрүүлэлт:* Тээвэр шатахууны зарцуулалтыг жолоочийн тооцооны хуудсанд холбогдох зааврын дагуу үнэн зөв хөтөлж, ямар ажлаар хаашаа явсныг тодорхой бичиж толилуулаагүй зөрчил дутагдал илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дүгээр зүйлийн 6.4.1[4], Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3[5], Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралт 1 тус тус нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Жолоочийн тооцооны хуудсыг иж бүрэн хөтөлж, тээвэр шатахууныг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах.

*5.2.2 Илрүүлэлт* Төрийн албан хаагчийн албан томилолтоор ажилласан албан томилолтын байр, хоолны зардлыг олгохдоо очиж ажилласан байгууллагын тамга тэмдэг дарсан ч, ажилласан хугацааг тэмдэглээгүй байхад хааж олгосон байна. Энэ нь Нягтлан бодогч бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолтой нийцэхгүй байна.

*5.2.1. Өгсөн зөвлөмж:* Дээд шатны удирдах байгууллагаас баталсан удирдамж, төлөвлөгөө, шийдвэрийн дагуу тодорхой хугацаагаар ажиллуулсан нөхцөлд байр, хоол, унааны зардлын төсвийг байгууллагын эрх бүхий албан тушаалтан батална шийдвэр гаргаж, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж, Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллах.

[3] бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр
[4] төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах
[5] үр ашигтай байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Тээвэр шатахууны зарцуулалтыг жолоочийн тооцооны хуудсанд холбогдох заавтын дагуу үнэн зөв хөтөлж, ямар ажлаар хаашаа явсныг тодорхой бичиж толилуулаагүй зөрчил дутагдал илэрлээ | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| Төрийн албан хаагчийн албан томилолтоор ажилласан албан томилолтын байр, хоолны зардлыг олгохдоо очиж ажилласан байгууллагын тамга тэмдэг дарсан ч, ажилласан хугацааг тэмдэглээгүй байхад хааж олгосон байна | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| **Дүн** | 2 | 0 | | | | | 2 | 0 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| www.shilendans.gov.mn цахим хуудсанд хугацаа хоцроож мэдээллэсэн | 1 | 0 | | | 1 | 0 | | |
| **Дүн** | 1 | 0 | | | 1 | 0 | | |